AGRC CONSULTING AUDIT LLC

АУДИТЫН ТАЙЛАН

“ББМНТ ББСБ” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлангийн аудит

Монгол улс, Улаанбаатар хот,
БЗД, 18-р хороо
Дамдинсүрэнгийн гудамж, 4-р эмнэлэгийн зүүн талд,
27-1 байр 1502 тоот
Утас: (976) 99040963,85558889
И.мэйл:agrcaudit@gmail.com
Веб хуудас: agrc.mn

ЭЙ ЖИ АР СИ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

Улаанбаатар хот, БЗД, 18-р хороо
Дамдинсүрэнгийн гудамж, 4-р эмнэлэгийн зүүн талд,
27-1 байр 1502 тоот
Утас: (976) 99040963,85558889
И.мэйл:agrcaudit@gmail.com

2026.3.27 № ГА-25-40

"ББМНТ ББСБ" ХХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ БОЛОН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛД

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ДҮГНЭЛТ

Бид "ББМНТ ББСБ" ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар "ББМНТ ББСБ" ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Энэхүү аудитын ажлыг бид Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх Аудиторын үүрэг хариуцлага* хэсэгт тусгав. Нягтлан бодогчдын олон улсын Ёс зүйн стандартын зөвлөл (НБОУЁСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын Ёс зүйн дүрэм (МНБЁЗД)-ийн дагуу бид компаниас хараат бусаар НБОУЁСЗ-ийн МНБЁЗД-ийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Аудитын явцад бидний олж авсан баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэдэгт итгэж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан болон аудитын тайланд ороогүй мэдээллээс бүрдэнэ.

"ЭЙ ЖИ АР СИ КОНСАЛТИНГ АУДИТ" ХХК № 01

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээн бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу бид аудитын хэсэг болгон мэргэжлийн үнэлэмж ашиглаж, аудитын турш мэргэжлийн үл итгэх байр суурийг баримталдаг. Түүнчлэн бид:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь залилан гэдэгт хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.

"ЭЙ ЖИ АР СИ КОНСАЛТИНГ АУДИТ" ХХК
№ 02

- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус, харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилд хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдтэй харилцдаг.

Бусад

Энэхүү тайланг Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 95.1-р зүйлд заасан хуулийн этгээд болох “ББМНТ ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

“ЭЙ ЖИ АР СИ КОНСАЛТИНГ АУДИТ” ХХК

Дэд захирал

Ж.Энхцэцэг

Хаяг: Улаанбаатар хот, БЗД, 18-р хороо
Дамдинсүрэнгийн гудамж, 4-р эмнэлэгийн зүүн талд,
27-1 байр 1502 тоот
Утас: (976) 99040963,85558889
И.мэйл:agrcaudit@gmail.com

Огноо: 2026 оны 03 дугаар сарын 27 .

“ЭЙ ЖИ АР СИ КОНСАЛТИНГ АУДИТ” ХХК
№ . 03 . .

АУДИТЛАГДСАН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН /дэлгэрэнгүй/

"ББМНТ ББСБ" ХХК

2025 оны 12 сарын 31, төгрөгөөр

№	Үзүүлэлт	12/31/2024	12/31/2025
1. ХӨРӨНГӨ			
1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	111,068,866.56	504,118,241.59
1.2	Зээл	4,668,601,661.70	5,332,940,515.06
1.3	Факторингийн тооцооны авлага	0.00	0.00
1.4	Үүсмэл санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.5	Хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.6	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.7	**Санхүүгийн хөрөнгийн дүн**	**4,779,670,528.26**	**5,837,058,756.65**
1.8	Татвар, НДШ-ийн авлага	0.00	0.00
1.9	Үндсэн хөрөнгө	78,541,656.72	82,628,205.65
1.10	Биет бус хөрөнгө	0.00	0.00
1.11	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.12	Бусад санхүүгийн бус хөрөнгө	32,180,740.33	14,599,998.50
1.13	**Санхүүгийн бус хөрөнгийн дүн**	110,722,397.05	97,228,204.15
1.14 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		**4,890,392,925.31**	**5,934,286,960.80**
2. ӨР ТӨЛБӨР		0.00	0.00
2.1	Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	0.00	0.00
2.2	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	0.00	0.00
2.3	Бусад эх үүсвэр	0.00	0.00
2.4	Үүсмэл санхүүгийн өр төлбөр	0.00	0.00
2.5	Бусад санхүүгийн өр төлбөр	0.00	0.00
2.6	Хоёрдогч өглөг	0.00	0.00
2.7	Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	0.00	0.00
2.8	**Санхүүгийн өр төлбөрийн дүн**	0.00	0.00
2.9	Татвар, НДШ-ийн өр төлбөр	**77,591,408.95**	**83,861,251.86**
2.10	Нөөц /Болзошгүй өр төлбөр /	0.00	0.00
2.11	Хойшлогдсон татварын өр төлбөр	0.00	0.00
2.12	Бусад санхүүгийн бус өр төлбөр	10,987,180.30	17,178,438.83
2.13	Санхүүгийн бус өр төлбөрийн дүн	**88,578,589.25**	**101,039,690.69**
2.14 НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		**88,578,589.25**	**101,039,690.69**
3. ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		0.00	0.00
3.1	Хувь нийлүүлсэн хөрөнгө	3,500,000,000.00	4,600,000,000.00
3.2	Өмчийн бусад хэсэг	0.00	0.00
3.3	Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	1,301,814,336.06	1,233,247,270.11
3.4 НИЙТ ӨМЧИЙН ДҮН		**4,801,814,336.06**	**5,833,247,270.11**
3.5 НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН		**4,890,392,925.31**	**5,934,286,960.80**

Аудитор: Л.Дэлгэрмаа

"ЭЙ ЖИ АР СИ КОНСАЛТИНГ АУДИТ" ХХК
№ ..06..

АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН /дэлгэрэнгүй/

"ББМНТ ББСБ" ХХК

2025 оны 12 сарын 31, төгрөгөөр

№	Үзүүлэлтүүд	12/31/2024	12/31/2025
1. Хүүгийн орлого			
1.1	Банканд байршуулсан хөрөнгийн	-	-
1.2	Санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	-	-
1.3	Зээлийн	1,349,447,951.07	1,724,530,875.25
1.4	Үнэт цаасны	-	-
1.5	Бусад	-	-
1.6	(Хүүгийн орлогын буцаалт)	-	-
1.7.Хүүгийн орлогын дүн		**1,349,447,951.07**	**1,724,530,875.25**
2	Хүүгийн зардал	-	-
2.1	Итгэлцлийн үр шим	-	-
2.2	Зээлийн	-	-
2.3	Үнэт цаасны	-	-
2.4	Бусад	-	-
2.5	(Хүүгийн зардлын буцаалт)	-	-
2.6.Хүүгийн зардлын дүн		-	-
3.Хүүгийн цэвэр орлого (1.7-2.6)		1,349,447,951.07	1,724,530,875.25
4.Эрсдэлийн сангийн зардал		506,700,354.96	13,240,033.86
5.Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого (3-4)		**842,747,596.11**	**1,711,290,841.39**
6.Бусад орлого		**115,716,242.40**	**42,989,950.00**
6.1	Хүүгийн бус орлого	115,716,242.40	42,989,950.00
6.2	Бусад орлого, олз	-	-
7. Бусад зардал		**465,774,312.87**	**472,574,802.07**
7.1	Хүүгийн бус зардал	465,774,312.87	469,716,373.63
7.2	Бусад зардал, гарз	-	2,858,428.44
8.Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)		**492,689,525.64**	**1,281,705,989.32**
9.Орлогын татварын зардал		49,545,906.45	128,170,598.93
10.Татварын дараах ашиг, алдагдал (8-9)		**443,143,619.19**	**1,153,535,390.39**
11.Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого,		-	-
12.Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)		**443,143,619.19**	**1,153,535,390.39**
13.Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
14.Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй		**443,143,619.19**	**1,153,535,390.39**

Аудитор: Л.Дэлгэрмаа

"ЭЙ ЖИ АР СИ КОНСАЛТИНГ АУДИТ" ХХК
№ 07

АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН /дэлгэрэнгүй/

"ББМНТ ББСБ" ХХК

12/31/2025
төгрөг

№	Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний сан	Бусад өөрийн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл						
1	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0				0.00	0.00
2	**Залруулсан үлдэгдэл**	**2,500,000,000.00**				**858,670,716.87**	**0.00**
3	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	0				443,143,619.19	443,143,619.19
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0				0	0
5	Өмчид гарсан өөрчлөлт	1,000,000,000.00				0	1,000,000,000.00
6	Хуваарилсан ногдол ашиг	0				0.00	0.00
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0				0	0
8	**2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл**	**3,500,000,000.00**				**1,301,814,336.06**	**4,801,814,336.06**
9	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0				-	0.00
10	**Залруулсан үлдэгдэл**	**3,500,000,000.00**				**1,301,814,336.06**	**4,801,814,336.06**
11	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	0				1,153,535,390.39	1,153,535,390.39
12	Бусад дэлгэрэнгүй орлого	0				0	0
13	Өмчид гарсан өөрчлөлт	1,100,000,000.00				0	1,100,000,000.00
14	Хуваарилсан ногдол ашиг	0				(1,222,102,456.34)	(1,222,102,456.34)
15	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0				0	0
16	**2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл**	**4,600,000,000.00**				**1,233,247,270.11**	**5,833,247,270.11**

Аудитор: Л.Дэлгэрмаа

"ЭЙ ЖИ АР СИ КОНСАЛТИНГ АУДИТ" ХХК
№ .08...

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /дэлгэрэнгүй/

"ББМНТ ББСБ" ХХК

2025 оны 12 сарын 31, төгрөгөөр

№	Үзүүлэлт	12/31/2024	12/31/2025
1.ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
1.1	Зээл, хүүгийн төлбөрт хүлээн авсан	8,128,342,723.00	8,200,059,023.59
1.1.1	Итгэлцлийн үйлчилгээнээс хүлээн авсан	-	-
1.1.2	Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан хүлээн авсан	-	-
1.1.3	Факторингийн үйл ажиллагаанаас хүлээн авсан	-	-
1.1.4	Бусад	258,321,048.37	42,989,950.00
1.6 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого		**8,386,663,771.37**	**8,243,048,973.59**
1.1.6	Олгосон зээл	7,593,235,877.29	6,964,398,357.74
1.1.7	Буцаан олгосон итгэлцэл, үр шим	-	-
1.1.8	Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан буцаан шилжүүлсэн	-	-
1.1.9	Факторингийн үйл ажиллагаагаар шилжүүлсэн	-	-
1.1.10	Ажиллагсдад олгосон	164,054,846.65	218,671,549.20
1.1.11	Татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	66,215,202.73	519,761,839.41
1.1.12	Ашиглалтын зардалд төлсөн	17,799,958.00	19,791,699.00
1.1.13	Бусад	724,879,603.00	127,376,153.21
1.15 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага		**8,566,185,487.67**	**7,849,999,598.56**
1.16 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		**(179,521,716.30)**	**393,049,375.03**
2.ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
2.1	Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө борлуулснаас хүлээн авсан	-	-
2.2	Хөрөнгө оруулалтаас хүлээн авсан	-	-
2.3	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулснаас хүлээн авсан	-	-
2.4	Үнэт цаас борлуулснаас хүлээн авсан	-	-
2.5	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.6 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого		-	-
2.7	Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.8	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.9	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.10'	Үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	-	-
2.11'	Бусад	-	-
2.12 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага		-	-
2.13 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		-	-
3.САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
3.1	Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлээс хүлээн авсан	-	-
3.2	Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан	-	-
3.3	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.4	Бусад	-	-
3.5 Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого		-	-
3.6	Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлд төлсөн	-	-
3.7	Хоёрдогч өглөгт төлсөн	-	-
3.8	Төлсөн ногдол ашиг	-	-
3.9	Бусад	-	-
3.10 Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага		-	-
3.11 Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		-	-
4. Валютын ханшийн зөрүү		-	-
5.Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		**(179,521,716.30)**	**393,049,375.03**
6.Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		**290,590,582.86**	**111,068,866.56**
7.Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		**111,068,866.56**	**504,118,241.59**
/1.16+2.13+3.11/		(179,521,716.30)	393,049,375.03
БЦМГ /7-6/		(179,521,716.30)	393,049,375.03
3 Зөрүү		-	-

Аудитор: Д.Дэлгэрмаа

"ЭЙ ЖИ АР СИ КОНСАЛТИНГ АУДИТ" ХХК
№ 09